

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД**



Х.НЯМБААТАР

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг нэгэнт оруулсан бол уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш найман жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглоно.” гэж заасан.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар бүлэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг зохицуулсан бөгөөд үүнд Жаран есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно.” гэж зааснаас бусад байдлаар тодорхой, тусгайлсан хугацааны хязгаарлалт тогтоогоогүй байна.

Түүнчлэн хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 6 сараас бусад тохиолдолд хэдийд ч гаргах эрхтэй байхаар заасан.

Гэтэл ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш найман жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглохоор заасан нь Үндсэн хуулийн дээрх үзэл санаанаас давсан, Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд олгосон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг хөндсөн зохицуулалт болсон гэж үзэхээр байна. Нөгөө талаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад аливаа хязгаарлалт тогтоох эрх хэмжээ Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д “... Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;” гэж заасан бөгөөд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг сонгуулийн эрх бүхий

иргэдийн олонхийн саналаар дэмжсэн бол уг асуудлыг шийдвэрлэгдсэнд тооцохоор зохицуулсан. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль бол төр, иргэний хооронд байгуулсан нийгмийн гэрээ учраас уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг ард иргэдээсээ асуух, хэлэлцэхийг хоёр арга замаар хэрэгжүүлэхээр Үндсэн хуульд заасан. Нэгд, ард түмний төлөөлөл болох Улсын Их Хурлаар дамжуулан, хоёрт, ард түмний төлөөллийн байгууллага ард нийтээсээ асуух нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд ард түмний санал шийдвэрлэх эрхтэй байхаар хуульчлагдсан. Гэтэл ард түмэн шаардаж байгаа, эсхүл дэмжсэн нөхцөлд найман жилийн хугацааны хязгаарлалтын улмаас уг эрхээ эдэлж чадахгүй нөхцөл байдалд хүрч Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлээс гадна Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан ард түмний засаглах эрх бүхэлдээ хөндөгдөж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь Үндсэн хуульд өмнө нь нэмэлт, өөрчлөлт орсон зохицуулалттай уялдаж, хөндөгдөх зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд дээрх хугацааны хязгаарлалтаас шалтгаалан өөрчлөлт ороогүй асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй нөхцөлд хүргэж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гээд мөн зүйлийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасан. Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн гадаад, дотоод бодлого, хүний эрх, эрх чөлөө, төрийн байгуулал гэх мэт Үндсэн хуульд тусгавал зохих асуудлыг шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед санаачлан хэлэлцэж, шийдвэр гаргах онцгой бүрэн эрхийг олгосон болохыг нэмж тодотгох нь зүйтэй.

Дэлхий нийтэд улс төр, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, улс орнууд дотоод, гадаад бодлогоо шинэ хандлага, шинэ нөхцөл байдалд чиглүүлж байна. Бид ч мөн дэлхий нийтийн шинэ дэг журамд тохируулан улс төр, эдийн засгийн бодлогоо шинэчлэх шаардлага тулгарах магадлалтай юм. Ийм цаг хугацааны хязгаарлалтаас шалтгаалан Монгол Улсын хөгжил, ард түмний нийтлэг эрх ашгийг хангах, төрийн байгууламж, парламентын бүгд найрамдах засаглалаа улам бүр бататган бэхжүүлэхэд шаардлагатай зохих өөрчлөлтөөс ухрах, цааргалах нь нөхөх боломжгүй эрсдэл дагуулна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш найман жилийн дотор уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт дахин оруулахыг хориглосон зохицуулалтыг хүчингүй болгох шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох агуулгыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, шийдвэрлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлд заасан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Үндсэн хуулийн үзэл санаа, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ ... засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна... сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан ард түмний засаглах эрх бүрэн хэрэгжих боломжтой болно. Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нөлөөлөл үзүүлэхгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, агуулгад бүрэн нийцэх бөгөөд хуулийн хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлага үүсэхгүй болно.

Хууль санаачлагч